210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,744,500.00	7,075,696.00	4,887,600.00	3,345,543.00
210404	Ном, хэвлэл	239,200.00	194,200.00	1,515,100.00	600,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	696,300.00	696,300.00	590,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,983,700.00	9,435,500.00	3,583,700.00	5,656,700.00
2105	Нормативт зардал	79,098,300.00	48,782,018.00	86,308,600.00	60,357,938.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,554,200.00	8,940,018.00	25,271,000.00	22,923,768.00
210502	Хоол, хүнс	58,095,900.00	34,443,900.00	56,589,400.00	33,515,270.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,448,200.00	5,398,100.00	4,448,200.00	3,918,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,234,500.00	23,382,850.00	9,840,200.00	9,294,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,452,100.00	1,600,500.00	748,800.00	516,000.00
210602	Тавилга	13,000,000.00	12,999,950.00	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	312,700.00	312,700.00	312,700.00	0.00
210604	Урсгал засвар	8,469,700.00	8,469,700.00	8,778,700.00	8,778,700.00
2107	Томилолт, зочны зардал	11,670,900.00	8,646,000.00	10,383,100.00	7,691,000.00
210702	Дотоод албан томилолт	11,670,900.00	8,646,000.00	10,383,100.00	7,691,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,589,700.00	29,884,054.00	27,293,800.00	25,284,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,821,800.00	20,460,197.00	22,089,200.00	21,889,810.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,692,100.00	1,328,358.00	2,878,800.00	2,538,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	213,950.00	539,100.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	795,700.00	340,675.00	795,700.00	88,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,600.00	66,000.00	88,600.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,403,400.00	7,341,800.00	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	188,300.00	133,074.00	188,300.00	29,540.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,700.00	0.00	60,700.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	450,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,886,900.00	25,084,630.00	29,539,500.00	28,286,920.00

Баянхайрхан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,085,000.00	18,584,400.00	14,244,400.00	14,178,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,801,900.00	6,500,230.00	15,295,100.00	14,108,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,693,200.00	19,686,200.00	46,216,200.00	46,070,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,693,200.00	19,686,200.00	46,216,200.00	46,070,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,502,000.00	7,495,000.00	14,684,100.00	14,538,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,691,200.00	11,691,200.00	30,462,100.00	30,462,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	1,070,000.00	1,070,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,058,900.00	47,310,000.00	149,800,000.00	65,121,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	109,058,900.00	47,310,000.00	149,800,000.00	65,121,000.00
223001	Бусад хөрөнгө	109,058,900.00	47,310,000.00	149,800,000.00	65,121,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	73,000,000.00	51,699,000.00	60,000,000.00	54,215,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	73,000,000.00	51,699,000.00	60,000,000.00	54,215,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,997,067,700.00	1,750,740,268.65	2,007,405,800.00	1,842,473,366.23
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,282,606,200.00	1,135,454,617.59	1,323,177,100.00	1,259,208,950.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,282,606,200.00	1,135,454,617.59	1,248,819,400.00	1,184,850,447.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.00	0.00	74,357,700.00	74,358,503.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	536,260,300.00	540,282,201.06	509,938,200.00	507,149,088.23
122005	Орон нутгийн төсвөөс	488,532,900.00	492,566,970.06	509,938,200.00	507,149,088.23
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	47,727,400.00	47,715,231.00	0.00	0.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,069,700.00	15,750,050.00	18,069,700.00	9,459,970.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,069,700.00	15,750,050.00	18,069,700.00	9,459,970.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	160,131,500.00	59,253,400.00	156,220,800.00	66,655,358.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,235,700.00	42,353,400.00	57,981,700.00	66,655,358.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	16,900,000.00	0.00	0.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	122,895,800.00	0.00	98,239,100.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	47,128,278.10	0.00	55,087,909.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	55,087,909.10	0.00	76,765,770.10
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	29.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	6.00	-
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	6.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110.00	117.00	110.00	108.00
620001	Удирдах ажилтан	12.00	7.00	12.00	11.00
620002	Гүйцэтгэх ажилтан	57.00	59.00	57.00	56.00
620003	Үйлчлэх ажилтан	38.00	43.00	38.00	38.00
620004	Гэрээт ажилтан	3.00	8.00	3.00	3.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	267.00	267.00	382.00	382.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	-	267.00	267.00
630001	Төрийн өмчит ЕБС	-	-	267.00	267.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	267.00	267.00	115.00	115.00

Баянхайрхан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	267.00	267.00	115.00	115.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	26.00	110.00	109.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	14.00	9.00	9.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	-	67.00	67.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	-	-	16.00	16.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	8.00	7.00	7.00
650010	Гэрээт ажилтан	3.00	4.00	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	-	-	8.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,208,877.00	131,798,424.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,208,877.00	131,798,424.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,208,877.00	50,816,062.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	8,766,165.00
210104	Урамшуулал	0.00	8,766,165.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	474,000.00
210302	Түлш, халаалт	0.00	474,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,125,440.00	236,100.00
210401	Бичиг хэрэг	0.00	154,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,125,440.00	81,200.00
2105	Нормативт зардал	15,404,241.00	17,694,065.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,404,241.00	17,694,065.00
2107	Томилолт, зочны зардал	360,000.00	84,000.00
210702	Дотоод албан томилолт	360,000.00	84,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,382,696.00	1,610,475.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,382,696.00	1,610,475.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,936,500.00	21,951,257.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,936,500.00	17,259,757.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	4,691,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	80,982,362.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	50,424,812.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	23,824,812.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	26,600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,020,812.00	30,557,550.60
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,020,812.00	30,557,550.60
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,229,689.00	131,799,328.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,229,689.00	131,799,328.64

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,505,689.00	59,711,449.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	724,000.00	72,087,879.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	904.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхайрхан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Г.Чулуунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхайрхан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 3/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан төр засгийн бодлого үйл ажиллагаатай нийцсэн, орон нутгийн онцлог нөөц чадавхыг бүрэн дайчилсан, судалгаанд суурилсан эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлж хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн, төрийн үйлчилгээг хүн амд ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэж улс аймгийн хэмжээнд тэргүүлэх түвшинд хүргэх гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах;
- Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжих, тамирчдын тив, дэлхий, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэх;
- Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон, насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлэх;
- Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж иргэдийг соён гэгээрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих;
- Бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлэх;
- Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;

- Судалгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн нийгмийн халамжийг зорилтод бүлэгт хүргэж, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин амьдралын чанарыг дээшлүүлэх;
- Эрчим хүчний найдвартай, аюулгүй тогтвортой байдлыг хангах;
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх;
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхайрхан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн нийт орлого 2,624.70 сая төгрөгийн 1.5 хувь буюу 39.37 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 29.52 сая төгрөгөөр тус тус тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 168.08 сая төгрөг болж өмнөх оноос 71.46 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 14.40 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 61.48 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 0.90 сая төгрөг нь эрүүл мэндийн төвийн, 91.30 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлагын дансны үлдэгдэл 224.41 сая төгрөг болж өмнөх оноос 14.27 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь холбогдох байгууллагуудын авлагын барагдуулалттай холбоотой байна. /төгрөгөөр/

Регистр	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Сум хөгжүүлэх сан	217,507,580.00	213,348,662.00
9036962	Хүүхдийн цэцэрлэг	6,635,699.00	978,702.00
9037004	Соёлын төв	389,850.00	471,812.00
9037039	Засаг даргын тамгын газар	175,000.00	175,000.00
9037047	Эрүүл мэндийн төв	13,972,547.90	0.00
9037012	Ерөнхий боловсролын сургууль	1,714,701.00	7,721,288.90
Нийт		238,680,676.90	224,410,165.90

Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 165.84 сая төгрөг болж өмнөх оноос 4.01 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Эрүүл мэндийн төвд ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,910.28 сая төгрөг болж өмнөх оноос 109.15 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 11.39 сая төгрөг болж өмнөх оноос 0.08 сая төгрөгөөр өссөн байна. /төгрөгөөр/

Регистр	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Орон нутгийн хөгжлийн сан	2,200,000.00	0.00
9036954	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	208,926.73	0.00
9037012	Ерөнхий боловсролын сургууль	6,635,699.00	1,714,701.00
9037039	Засаг даргын тамгын газар	168,049.00	0.00
9037047	Эрүүл мэндийн төв	2,099,420.03	9,571,240.00
9036962	Хүүхдийн цэцэрлэг	109,023.00	0.00
Нийт		11,312,094.76	11,394,964.00

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 4,457.22 сая төгрөг болж өмнөх оноос 48.44 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 2,007.40 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,007.40 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,797.60 сая төгрөгийг урсгал зардалд, 149.80 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 60.00 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,248.81 сая төгрөгийг улсын төсвөөс, 509.93 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18.06 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 74.39 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 57.98 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 98.23 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,184.85 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 507.17 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 9.45 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 74.35 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 66.65 сая төгрөг, нийт 1,842.47 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 164.93 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 66.65 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 8.67 сая төгрөгөөр давсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,820.91 сая төгрөг буюу 90.70 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 10.26 сая төгрөгийг сумын төсөвт, 4.40 сая төгрөгийг аймгийн төсөвт, 0.00 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.00 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 59.71 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 72.08 сая төгрөгийн, нийт 131.79 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 131.79 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс, 106 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 44 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 3 мэдээллийг огт мэдээлээгүй, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Баянхайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдөж, биелэлт нь 69.7 хувьтай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 0.11 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.11 сая төгрөгийн алдааг залруулж, 0.00 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулийн мөнгөн гүйлгээний тайлан дахь орлогыг дутуу тайлагнасан алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 /тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.10 /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” дахь заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Эрсдэл: Иргэд, олон нийт тухай бүр мэдээллээр хангаагдахгүй байх

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	2	41.36	1	39.69	-	0.00	-	0.00	1	1.65
2	Эрүүл мэндийн төв	3	9.38	1	2.36	1	1.17	-	0.00	1	5.87
3	Хүүхдийн цэцэрлэг	1	1.65	-	0.00	-	0.00	-	0.00	1	1.65
4	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	3.46	-	0.00	1	0.31	-	0.00	2	3.15
5	Ерөнхий боловсролын сургууль	1	1.65	-	0.00	-	0.00	-	0.00	1	1.65

6	Төвлөрүүлэн захирагч	2	0.11	1	0.11	-	0.00	-	0.00	1	0.00
Дүн		12	57.61	3	42.16	2	1.48	0	0.00	7	13.97

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

2022.03.25